



ДАТ КОНСАЛТИНГ ХХК



ЯПОНЫ МЕНЕЖМЕНТИЙН САЙН ТУРШЛАГЫГ СУДЛАХ СУРГАЛТ-АЯЛАЛ ХӨТӨЛБӨР

Аялалын чиглэл: Улаанбаатар – Токио – Шизүока – Яманаши
Аялалын хугацаа: 7 шөнө, 8 өдөр
Аялал эхлэх өдөр: 4 сарын 7 – 14, 5 сарын 19-26, 6 сарын 02-09, 9 сарын 23-30, 10 сарын 21-28, 11 сарын 18-25, 12 сарын 16-23

Аялалын хөтөлбөр	Хоол	Буудал
<p>Өдөр 1. Улаанбаатар – Нарита - Токио Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал дээр өглөө 05:00 цагт цуглан бүртгэлээ хийлгэнэ. Онгоц 08:00 цагт Улаанбаатараас хөөрч Токио хотын Нарита нисэх онгоцны буудал дээр 13:30 цагт бууна. Хилээр нэвтэрч ачаагаа авсны дараа аялалын ахлагчийн хамт нутгийн хөтөчтэй уулзан автобусаар 15 минут орчим яваад Нарита хотын зочид буудалдаа ирж байрлана.</p>	<p>- -Онгоц -х</p>	<p>Зочид буудал Тусгай автобус</p>
<p>Өдөр 2. Нарита – Шизүока муж - Фүжи уул Өглөөний цай зочид буудалдаа уусны дараа өрөөгөө хүлээлгэж өгөөд Шизүока муж руу явна. Энэ өдөр дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Кавагүчи нууранд очиж Фүжи уулыг холоос харна. Мөн Фүжи уулын 2305 метрийн өндөрт байдаг зогсоол хүртэл автобусаар гарч Фүжи уулын оройг тольдон бэлэг дурсгалын дэлгүүрт худалдаа хийнэ. 2014 онд Юнескогийн Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Фүжи уул нь Японы 108 галт уулын хамгийн өндөр нь бөгөөд далайн түвшнээс дээш 3776 метрт өргөгдсөн байна Үдээс хойш Японы уламжлалт халуун рашаанд орно. Японы халуун рашаан нь хүний арьсыг зөөлрүүлж, залуужуулдаг. Оройн нь зочид буудалдаа ирж амарна.</p> 	<p>Өглөө Өдөр -х</p>	<p>Зочид буудал Тусгай автобус</p>
<p>Өдөр 3. Шизүока муж – Сургалт -Токио  Өглөөний цайгаа зочид буудалд уусны дараа өрөөгөө хүлээлгэж өгөөд Шизүока муж руу явна. Замд автобусанд байгууллага тус бүрийн танилцуулга явагдана. Энэ өдөр ажлын байрны бүтээмжийг дээшлүүлэх 5С-ийг амжилттай хэрэгжүүлсэн Фүкасава дэнко цахилгаан хагас дамжуулагчийн үйлдвэр дээр 5С-ийн сургалт хийсний дараа үйлдвэртэй танилцаж 5С болон БО, ХАБЭА-н менежментийг хэрэгжүүлсэн үйлдвэрийн үйл ажиллагааг харна. Үүний дараа Япон улсын үйлдвэр, компанийн менежментийн 5С-ийг судлан баталгаажуулсан сертификат гардаж авна. Өдрийн хоолны дараа Готэнба аутлетийн дэлгүүрт очиж худалдаа хийнэ. Готэнба аутлетийн дэлгүүр нь Шизүока мужд байдаг ба 210 төрлийн дэлхийн болон Японы брэндийн дэлгүүр төвлөрсөн байдаг. Орой зочид буудалдаа амарна.</p>	<p>-Өглөө -Өдөр -х</p>	<p>Зочид буудал Тусгай автобус</p>

<p>Өдөр 4. Токио Өглөөний цайгаа уусны дараа дэлхийн хамгийн өндөр цамхаг Скай Три дээр гарч Токио хотын бүтээн байгуулалтыг тольдоно. Энэхүү аялалаар Япон улсын нийгэм болон Япон хүний “хүнийг дээдлэх зан чанар, хувь хүний хүмүүжлийн” талаар ярилцана. Үүний дараа эртний Буддын Сэнсожи сүм, Шинтогийн шашны Асакуса сүм болон бэлэг дурсгал, худалдааны гудамжтай танилцана. Өдрийн хоолны дараа Шибүяа дүүрэгт очно. Энд эзэндээ үнэнч Хачико нохойны хөшөө болон дэлхийд алдартай хамгийн олон хүн зөрдөг замын уулзвар гарцыг харна. Орой зочид буудалдаа байрлан амарна.</p>		<p>-Өглөө -Өдөр -х</p>	<p>Зочид буудал</p> <p>Тусгай автобус</p>
<p>Өдөр 5. Токио</p>  <p>Өглөөний цай зочид буудалдаа ууна. Энэ өдрийн байгууллагын сургалт аялалаар Японы Асахи сонингийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцана. Өдөр нь Токио хотын хог хаягдлын үйлдвэрийн аюулгүй байдал, хог хаягдлын менежменттэй танилцана. Мөн нийтийн тээврийн зохион байгуулалтыг харж танилцан зорчиж явах өдөр байна. Орой зочид буудалдаа байрлан амарна.</p>	<p>-Өглөө -Өдөр -х</p>	<p>Зочид буудал</p>	<p>Нийтийн тээвэр</p>
<p>Өдөр 6. Токио хот Өглөөний цай зочид буудалдаа ууна. Энэ өдөр чөлөөт хөтөлбөртэй.</p>	<p>-Өглөө -х -х</p>	<p>Зочид буудал</p>	<p>Зочид буудал</p>
<p>Өдөр 7. Токио - Нарита Өглөөний цай зочид буудалдаа ууна. Энэ өдөр ХАБ-ын менежменттэй танилцах өдөр. Японы үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент, япон үйлдвэрийн үйл ажиллагаатй танилцана. Орой Наритагийн зочид буудалд байрлан амарна.</p>	<p>-Өглөө -Өдөр -х</p>	<p>Зочид буудал</p> <p>Тусгай автобус</p>	<p>Зочид буудал</p>
<p>Өдөр 8. Нарита - Улаанбаатар Өглөөний цай зочид буудалдаа ууна. Түүний дараа ерөөгөө хүлээлгэн өгөөд Наритагийн ОУНОБ руу явна. Онгоц 14:30 т хөөрч, Улаанбаатарт 18:30 т газардана. Үүгээр аялал өндөрлөх болно.</p>	<p>- Өглөө - Онгоц</p>	<p>Онгоц</p> <p>Тусгай автобус</p>	<p>Онгоц</p> <p>Тусгай автобус</p>

<p>Хүний тоо Том хүн</p>	<p>20 хүн 5,600,000₮</p>
<p>Аялалын зардалд багтсан:</p> <ul style="list-style-type: none"> - Японы 3* бизнес зочид буудалд нэг өрөөнд хоёроор байрлана - <u>Олон улсын нислэгийн тийз</u> - Гэнэтийн ослын даатгал - <u>Визний хураамж</u> - Аялалын хөтөлбөрт орсон хоол - Жуулчны автобусны үйлчилгээ - Монгол хэлтэй аялалын ахлагч, орчуулагч 	<p>Аялалын зардалд багтаагүй:</p> <ul style="list-style-type: none"> - “Аялалын зардалд багтсан”-аас бусад зардал - Хувь хүний хэрэглээний зардал - Хөтөлбөрт ороогүй оройн хоол
<p>Хөтөлбөр зохион байгуулагч: ДАТ Консалтинг ХХК-ийн менежер Г.Оюундарь 99104029 Ньюжуулчин турс ХХК-ийн менежер Б.Эрдэнэтуяа 99062826</p>	